



УНШИЖ ОЙЛГОХ ЧАДВАРЫН СУДАЛГАА (Багшийн сургуулийн 2 дугаар курсийн оюутнуудын жишээн дээр)

Д.Ганболд^а^аМУБИС-Багшийн сургууль, багш, доктор

Холбоо барих зохиогч: ganbold.d@msue.edu.mn

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

Хураангуй

Багшийн сургуулийн 207 оюутнаас “Read-Dag”¹ сорил, ярилцлагын аргаар судалгаа авсан бөгөөд тэдний 15.5% нь нийслэл, 30% нь аймгийн төв, 54.6% нь суманд ерөнхий боловсрол эзэмшжээ. Оюутнуудын уншиж ойлгох чадвар 35.7% нь хангалтай (эх төвтэй уншигч буюу мэдээллийг ашиглахдаа өмнөх мэдлэгт суурилан, санааг ойлгохын зэрэгцээ ерөнхийлөн ухаарч, ялгааг нь гаргаж, агуулга, бүтцийг задлан шинжилж, гол санааг ургуулан бодож, тайлбарлах), 52.2% нь дундаж (зохиогч төвтэй уншигч буюу зохиогчийн хэлснийг давтаж хэлэх), 12.1% нь хангалтгүй (унших техник эзэмшсэн) түвшинд байна. Байршлаар нь авч үзвэл, нийслэлд ерөнхий боловсрол эзэмшсэн оюутнуудын уншиж ойлгох чадвар (2.41%) сум (2.20%) болон аймаг (2.21%)-ийн төвд ерөнхий боловсрол эзэмшсэн оюутнуудынхаас тодорхой түвшинд илүү бол, нийслэлд ерөнхий боловсрол эзэмшсэн оюутнуудын голч (2.956), аймаг болон суманд ерөнхий боловсрол эзэмшсэн оюутнуудын голчоос бага байна. Түүнчлэн уншиж ойлгох чадвар нь хангалтай сайн байгаа оюутны голч дүн өндөр бөгөөд голч дүн, уншиж ойлгох чадварын түвшин хоёр нь хоорондоо хүчтэй хамраалтай ($r=0.468$) байна. Оюутнуудын уншиж ойлгох чадварыг хөгжүүлэхийн тулд “Унших стратеги” сонгон судлах хичээлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх нь тэдний хөгжлийг дэмжих нэг шийдэл гэж үзлээ.

Түлхүүр үг

PISA, унших стратеги, эх төвтэй уншигч, зохиогч төвтэй уншигч, унших техник


Удиртгал

Багш, бага ангийн боловсрол мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын уншиж ойлгох чадварыг сорил (тест)-ын аргаар авч, асуудлыг тодруулах зорилгын хүрээнд, Багшийн сургуулийн 2-р курсийн оюутнуудаас уншиж ойлгох чадварын судалгаа

1 Read-Dag нь сорилын нэр бөгөөд Read-унших, Dag-Дагдан гэсэн нэрийн эхний үе

авах, судалгааны үр дүнг боловсруулж, үр дүнг задлан шинжилж тайлбарлах, уншиж ойлгох чадварыг сайжруулах санал боловсруулах зорилтын дагуу энэхүү судалгааг зохион байгууллаа. Судалгаанд 2 дугаар курсийн 207 оюутан хамрагдсан бөгөөд, үр дүнг SPSS программ ашиглан, статистик боловсруулалт хийж гаргасан. PISA2 нь 15 настай суралцагч унших, математик, байгалийн ухааны мэдлэг, ур чадвараа бодит амьдралын сорилтуудыг даван туулахад хэрхэн ашиглаж байгааг тодорхойдог олон улсын түвшинд зохион байгуулдаг үнэлгээний хөтөлбөр юм. Монгол Улсын хувьд 2022 онд анх удаа PISA-д хамрагдсан бөгөөд 7276 суралцагч оролцож, мэдлэг, ур чадварын түвшин Математик-425, Унших чадвар-378, Байгалийн ухаан-412 гэж үнэлэгдлээ. Унших чадварын үнэлгээний хувьд авч үзвэл OECD-ийн дундаж 67 хувьтай, Монгол улс 36 хувьтай байна (Зураг 1). Энэ нь судалгаанд хамрагдсан сурагчдын хувьд авч үзвэл 10 сурагч тутмын 6 нь уншиж ойлгох чадварын хувьд хөгжүүлэх шаардлага байгааг харуулж байна (PISA 2022, National Report).

Зураг 1. Мэдлэг, ур чадварын түвшин



“Монгол хэлний арга зүй” хөтөлбөрийг судалж буй оюутнууд бие даан судлах ном, зохиол, судалгааны бүтээлийг унших даалгаврын гүйцэтгэлийн хувь 55,7% байна. Эдгээр нь боловсролын бүх түвшний суралцагчдын хувьд унших ойлгох чадвар хөгжил нь тулгамдсан асуудал болсныг харуулж байна.

Уншиж ойлгох чадвар

Хэл шинжээчид, танин мэдэхүйн сэтгэл зүйчид ойлгох үйл явцад нөлөөлдөг гол хүчин зүйлийн харилцан хамаарлыг схемийн онолд тулгуурлан хөгжүүлсээр байна (Pearson P., 2017). Схемийн онол нь уншигч текстийн утга санааг ойлгох болон түүний агуулгаас суралцахад өмнөх мэдлэгээ хэрхэн үр дүнтэй ашиглаж байгаагаар тайлбарлагддаг (Rumelhart, 1980). Ойлгох гэдэг нь уншигч текстийн агуулгыг өөрийн суурь мэдлэгтэй холбох чадвар юм (An, 2013). Р.Андерсоны тэмдэглэснээр “ойлголтын бүхий л үйлдэл нь ертөнцийн тухай мэдлэгийг агуулдаг” (Anderson R. C., 1990). Уншигч бүр унших үйл ажиллагааны алхам тутамд уншсан текстийн

утга санаагаар уялдаа холбоо бүхий загвар бүтээдэг гэж схемийн онолд ойлголтын талаарх конструктивист үзлийг дэвшүүлсэн (Smagorinsky, 2001) байдаг. Схемийг текстийн бүтэц, агуулга, соёлын тухай мэдлэг, хэл шинжлэлийн чадвар гэж ангилсан байдаг (Urquhart A.H, 2013). Өөрөөр хэлбэл, суралцагчдын суурь мэдлэг хангалтгүй байх нь тэдний уншиж ойлгох чадварт нөлөөлдөг.

Зохиол бүтээлийг уншиж ойлгох гурван загвар байдаг (Carter, 1991). Энэ нь соёлын загвар, (тодорхой текст дэх нийгэм, улс төр, түүхэн нөхцөл байдлыг судалж, тайлбарлахыг суралцагчдаас шаарддаг) хэлний загвар, (суралцагчдад тодорхой жишээ болгон текстэд системтэй, аргачлалтай хандах, хэлний шууд ба шууд бус нэрлэлтийн шинж чанаруудыг мэдэх боломжийг олгодог) хувь хүний хөгжил (текст дэх хэлний тодорхой хэрэглээ, мөн түүнийг соёлын тодорхой нөхцөлд байрлуулахад чиглэгддэг) юм (Carter & Long, 1991; Mustakim et al., 2014; Rashid et al., 2010). Дүгнэж хэлбэл, оюутны уншиж ойлгох чадварт унших техник, унших стратегийг эзэмшсэн байдал нөлөөлөхөөс гадна, ЕБС-д уншигчийн эзэмших соёлын загвар, хэлний загвар, хувь хүний хөгжил ихээхэн нөлөөлдөг гэж үзэх хандлага юм.

Судалгааны үр дүн

Судалгаанд 2 дугаар курсийн 207 оюутан хамрагдсан бөгөөд 15,5% нь нийслэл, 30% нь аймгийн төв, 54,6% нь суманд ерөнхий боловсрол эзэмшсэн байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Байршлын судалгаа

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Нийслэл	32	15.5	15.5	15.5
	Аймгийн төв	62	30.0	30.0	45.4
	Сум	113	54.6	54.6	100.0
	Total	207	100.0	100.0	

Оюутнуудын уншиж ойлгох чадварыг Боловсрол судлалын шинжлэх ухаантай холбоотой эхийг уншуулж, Блумын таксономын 6 түвшний сонгох, харгалзуулах, нөхөх, хариулж бичих хэлбэрийн 13 асуулт бүхий сорил, асуултын дагуу ярилцах гэсэн хоёр хэлбэрээр тодруулсан болно.

Оюутнуудын 35,7 % нь уншиж ойлгох чадвар хангалттай түвшинд эзэмшсэн, 52,2 % нь унших чадвараа хөгжүүлэх шаардлагатай, 12,1 % нь онцгой анхаарах шаардлагатай гэсэн үр дүн гарчээ (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Уншиж ойлгох чадварын түвшин

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Хангалттай	74	35.7	35.7	35.7
	Дундаж	108	52.2	52.2	87.9
	Дунджаас доогуур	25	12.1	12.1	100.0
	Total	207	100.0	100.0	

Байршлаар нь авч үзвэл, нийслэл хотод ерөнхий боловсрол эзэмшсэн оюутнуудын

уншиж ойлгох чадвар сум болон аймгийн төвд ерөнхий боловсрол эзэмшсэн оюутнуудынхаас тодорхой түвшинд илүү байна (Хүснэгт 3). Харин аймгийн төв болон суманд ерөнхий боловсрол эзэмшсэн оюутнуудын уншиж ойлгох чадварын хооронд ялгаатай байдал ажиглагдсангүй.

Хүснэгт 3. Уншиж ойлгох чадварын түвшин (байршлаар)

	N	Mean	Std. Deviation	Std. Error	95% Confidence Interval for Mean		Minimum	Maximum
					Lower Bound	Upper Bound		
Нийслэл	32	2.41	.615	.109	2.18	2.63	1	3
Аймгийн төв	62	2.21	.681	.086	2.04	2.38	1	3
Сум	113	2.20	.643	.060	2.08	2.32	1	3
Total	207	2.24	.651	.045	2.15	2.33	1	3

Уншиж ойлгох чадвар нь хангалттай сайн байгаа оюутны голч дүн өндөр байгаа бөгөөд энэ нь уншиж ойлгох стратеги эзэмшсэн оюутан амжилттай суралцдагийг харуулж байна. Голч ба түвшин 2 хүчтэй хамааралтай байна.

Хүснэгт 4. Голч дүн ба уншиж ойлгох чадварын хамаарал

			голч	Түвшин
Spearman's rho	голч	Correlation Coefficient	1.000	.468**
		Sig. (2-tailed)	.	.000
		N	207	207
	Түвшин	Correlation Coefficient	.468**	1.000
		Sig. (2-tailed)	.000	.
		N	207	207

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан оюутнуудын уншиж ойлгох чадвар 35.7% хангалттай (эх төвтэй уншигч), 52,2% дундаж (зохиогч төвтэй уншигч), 12,1% нь хангалтгүй (унших техник эзэмшсэн) түвшинд байна.
2. Ерөнхий боловсролыг нийслэл хотод эзэмшсэн оюутнуудын уншиж ойлгох чадвар, аймаг болон сумдад Ерөнхий боловсрол эзэмшсэн оюутнуудаас өндөр байна.
3. Уншиж ойлгох чадвар нь хангалттай сайн байгаа оюутны голч дүн өндөр бөгөөд голч дүн, уншиж ойлгох чадварын түвшин хоёр нь хоорондоо хүчтэй хамраалтай ($r=0.468$) байна.
4. Казак оюутнуудын уншиж ойлгох чадвар 61,1 буюу хамгийн доогуур үзүүлэлттэй байна.

Санал

Энэхүү судалгааг цаашид өргөн хүрээг хамруулан үргэлжлүүлэхээр төлөвлөж байна. Оюутнуудын уншиж ойлгох чадварыг хөгжүүлэхийн тулд мэргэжлийн текстийг уншиж ойлгох стратегийг заах нь тулгамдсан асуудал болсон байна. Иймд Унших стратеги гэсэн шинэ хөтөлбөр боловсруулж сонгон судлах хэлбэрээр туршин хэрэгжүүлэх шаардлагатай. *Схемийн онолын хувьд авч үзвэл* уншиж ойлгоход суурь мэдлэг чухал үүрэгтэй тул оюутнуудын унших агуулгын хүрээг өргөжүүлж, боловсрол судлалын агуулга бүхий ном зохиолыг үе шаттай нэмэлтээр уншуулах хэрэгтэй.

Ном зүй

- An, S. (2013). Schema Theory in Reading. *ACADEMY PUBLISHER Manufactured in Finland*, 132.
- Anderson, R. C. (1990). The psychology of learning and motivation: Inferences and text comprehension. *Inferences about word meanings*, 1-16.
- Carter, R. &. (1991). Teaching literature. *Harlow: Longman*, 15.
- Pearson, P. (2017). *The Roors of Reading Comprehension Instruction*. New York: The Guilford Press.
- Rumelhart, D. (1980). Schemata: the building blocks of cognition. *Journal of Behavioral and Brain Science*, 35-58.
- Smagorinsky, P. (2001). If meaning is constructed, what is it made from?: Toward a cultural theory of reading. *Smagorinsk*, 133-169.
- Urquhart A.H, C. J. (2013). *Reading in a Second Language: Process, Product, and Practice*. New York: Taylor & Francis Group.

STUDY OF READING COMPREHENSION (2nd year students of teachers school)

^aGanbold Dagdan

^aPh.D., Lecturer, Teachers School, MNUE

Corresponding author: ganbold.d@msue.edu.mn 

Abstract

207 students of teachers' schools were surveyed by means of "Read-Dag" tests and interviews. 15.5% of them received general education in the capital, 30% in provincial centers, and 54.6% in Sumatra. 35.7% of students' reading comprehension ability is adequate (source-centered reader or when using information based on previous knowledge, while understanding ideas, generalize, make distinctions, analyze content and structure, develop and explain main ideas), 52.2% is average (author-centered the reader or repeating what the author said), 12.1% are at an insufficient level (reading techniques mastered). Considering the location, the reading comprehension ability of students who received general education in the capital (2.41%) is higher than that of students who received general education in the center of sum (2.20%) and provinces (2.21%), while the average of students who received general education in the capital (2.956), It is lower than the average of students who received general education in the province and Sumatra. In addition, students with good reading comprehension ability have higher GPA, and there is a strong correlation between GPA and reading comprehension level ($r=0.468$). In order to develop the reading comprehension skills of the students, it was considered that one of the solutions to support their development is to develop and implement a curriculum for elective study of "Reading Strategies".

Keywords

PISA, reading strategies, text-centered readers, author-centered readers, reading techniques